



№05 (144)

2023 оны 05-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

**МЭДЛЭГ, УР ЧАДВАР
ТЭМЦЭЭН-2023**

2-р нүүрт

**2023 ОНЫ 4-Р
САРЫН ТЭЗҮ**

3-р нүүрт

**2023 ОНЫ 4-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

4-р нүүрт

**"CES 2023"
ҮЗЭСГЭЛЭН**

6-р нүүрт

**СПОРТЫН
МЭДЭЭНИЙ ТОЙМ**

7-р нүүрт

**БҮСЭЛХИЙ НУРУУНЫ
ӨВДӨЛТ**

8-р нүүрт



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, sxa@tpp4.mn эсвэл СХА-нд файлаар болон бичгээр өгч болно.

www.tpp4.mn/erchim



“МЭДЛЭГ, УР ЧАДВАР ТЭМЦЭЭН”

Компанийн Захиргаа хүний нөөцийн алба, Засварын алба хамтран 2023 оны 3 сарын 27–ноос 5 сарын 5 хооронд засварын ажиллагсдын дунд “Мэдлэг, Ур чадвар тэмцээн” зохион байгууллаа.

Тэмцээнд 9 засварын мастер тус бүр 8 засварчины хамтаар нэг баг болон, 9 багт хуваагдан, нийт 81 оролцогч 1 сарын хугацаанд мэдлэг, ур чадвар, арга туршлага, мэргэн ухаанаараа өрсөлдлөө.

Уг тэмцээний зорилго засварчдын мэргэжлийн ур чадвар, тэдний онолын мэдлэгийн хүрээг дээшлүүлэх, цехүүдийн засварын чанар засварчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, бүтээлч байдал, ажил хэрэгч санаачлагыг өрнүүлэх харилцан туршлага судлахад оршиж байлаа.

Оролцогчид Цахилгааны схем, монтаж, угсралтын тэмцээн, Метал хийцийн тэмцээн, Хаалтны тэмцээн, Эргэх механизмын тэмцээн, ДХХА-ийн мэдлэг, ур чадвар, оногдсон сэдвийн дагуу сургалтын самбарын эх бэлтгэх, гэрийн даалгаварт өгөгдсөн бүтээлч ажлыг бүтээх, багийн мэндчилгээ, техникийн онолын асуултууд зэрэг 9 даалгаврыг гүйцэтгэсэн ба багуудын оноо хэдхэн бутархай тоогоор зөрж байр эзэлсэн

нь тэмцээнд оролцогчдын мэдлэг, ур чадвар тэнцүүхэн байгааг харууллаа.

Багуудын гэрийн даалгаварт гүйцэтгэсэн бүтээлч ажлууд нь инженерийн нарийн тооцоо бүхий шинэ санаа, шинэлэг технологийг нэвтрүүлсэн байсан ба зах зээл дээр хэдэн саяар үнэлэгдэх багаж тоног төхөөрөмжийг хямд төсөр байдлаар шийдэж, ашиглалтаас хасагдсан бараа материалыг дахин ашигласан нь цаашид компанийн технологи үйл ажиллагаанд нэвтрүүлэх бүрэн боломжтой төдийгүй хөдөлмөрийг хөнгөвчилж ажлын бүтээмжийг дээшлүүлсэн эдийн засгийн үр ашигтай бүтээлүүд байлаа.

Багийн нийлбэр оноогоор ЦЦ-ийн засварын мастер Ц.Цогбадрах ахлагчтай “Есөн Эрдэнэ” баг тэргүүн байр эзэлж багаараа дэлхийн аялал жуулчлалын үзэсгэлэнт газар болох Турк улсын 3 хотоор аялах эрх, дэд байранд шалгарсан ТЦ-ийн засварын мастер М.Дэмбэрэл ахлагчтай “Гал гал” багийн эрч хүчтэй залуус МУ-ын үзэсгэлэнт байгаль Алтай таван богдод аялах эрхээр тус тус шагнагдлаа. Мөн Компанийн захиргаанаас оролцсон бүх багуудад Дурсамж, мөнгөн шагналын хамт гардууллаа.



ЦЦ-ийн Засварын мастер Ц.Цогбадрах ахлагчтай “Есөн Эрдэнэ” баг



“МЭДЛЭГ, УР ЧАДВАР ТЭМЦЭЭН”



ТЦ-ийн засварын мастер М.Дэмбэрэл ахлагчтай “Гал гал” баг





That Might Motivate You №13

SUCCESS = WRITE DOWN ALL YOUR FEARS AND TITLE IT "TO DO LIST"

IN EVERYONE'S LIFE THERE ARE GOOD DAYS AND BAD DAYS

YOUR HEART AND YOUR BRAIN TOGETHER HAVE TO BE PILOTS OF YOUR LIFE

TODAY I WILL DO WHAT OTHERS DON'T, SO TOMORROW I CAN DO WHAT OTHERS CAN'T.



2023 ОНЫ 4-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас 7566.556 мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 34.820 мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг 7531.736 мян.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 440 МВт, дээд ачаалал 642 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	340.2	347.7	7.5	102.2
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	388.1	388.1	-	100.0

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - 102,2%, ДЭХ - 100,0% биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
69	7566.556	19	1880.052	1	34.820	642	440	7531.736	-

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд 632.113 мян.кВтц буюу 90.0 сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдсан. Оны эхнээс 358.396 мян.кВтц буюу 14.9 сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдан авч, 1990.635 мян.кВтц буюу 121.3 сая. төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, авлага өглөгийн зөрүүгээр 106.4 сая.төгрөгний ашигтай ажиллалаа.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс 37.5 сая.кВтц-аар давуулан 112.1 %-н биелэлттэй, оны эхнээс 87.1 сая.кВтц-аар давуулж, 105.8 % -ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 4-р сартай харьцуулбал 36.2 сая.кВтц буюу 11.6%-н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт 62.7 мян.Гкал-аар давж 119.3%-н биелсэн. Оны эхнээс нийт төлөвлөгөө 38.3 мян.Гкал-аар илүү түгээж 101.8 %, үүнээс “УБДС” ХК-д нийлүүлэх дулаан 10.0 мян.Гкал-аар давж 100.5%-н биелэлттэй байна. Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 4-р сартай харьцуулбал 44.7 мян.Гкал буюу 13.0%-н өсөлттэй байна.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 7 зуух, 6 турбин оролцсон. Сарын дунджаар 5.96 зуух, 5.93 турбинтэй ажиллаж, 0.78 зуух бэлтгэлд, турбин бэлтгэл тоноглолгүй байлаа. К-3-д төлөвлөгөөт их засвар, ТГ-7-д дунд засвар хийгдэж байна.

Мазутын зарцуулалт

Энэ сард 100 тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс 63 тн-г түлж, 37 тн мазут хэмнэсэн. Тайлант хугацаанд 3 удаагийн хүйтэн галлагаанд 60 тн, 1 удаагийн халуун галлагаа хийж 20 тн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар 21 тн мазут зарцуулсан.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	175.000	177.293	2.293	101.3
Шивээ-Овоо	мян.тн	140.000	135.650	-4.35	96.9
Бүгд	мян.тн	315.000	312.943	-2.057	99.3

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш 0.052 гр/кВтц-аар, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш 0.048 кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс 37 тн жишмэл түлш буюу 78 тн бодит түлш /илчлэг 3319 ккал/кг/ хэмнэсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ-аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг 0.12%-иар буюу 487.628 мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	4-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	29.22	28.91
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.57	4.52
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	8.11	8.02
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	1.23	1.21
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.54	0.54

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөлтөөс 1.2% буюу 21411 тн-оор хэмнэж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт 6087 тн нэмэгдсэн байна. Осмосын халаагч уурын зарцуулалт 3905 тн байлаа. Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд: 74847 м³
- Зууханд: 165 м³ ус өгсөн.
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт – 8969 м³ байлаа.



2023 ОНЫ 4-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 4-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 7 бүртгэгдсэнээс зуух 4 удаа, турбин 3 удаа зогссон. Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар
1	Зуух	2	-	2	-	1	1	-	3	5	4
2	Турбин	-	1	-	-	1	1	2	1	3	3
	Дүн	2	1	2	-	2	2	2	4	8	7

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ТДЦ-1 (2.970.000 ₮), ЦЦ-4 (217.994.400 ₮), ДХХАЦ-1 (15.108.336 ₮) **Бүгд-6 (236.072.736 ₮)**
- Мазут зарцуулалтын акт: ЗЦ-1 (37.646.627 ₮) **Бүгд-1 (37.646.627 ₮)**
- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: ТДЦ-1 (2.970.000 ₮), ЦЦ-3 (381.895.319 ₮), ДХХАЦ-1 (5.280.000 ₮), СХА-1, СБХ-1 **Бүгд-7 (390.145.319 ₮)**

Нийт 14 ширхэг (663.864.682 төгрөг) акт тогтоогдсон.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °C)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	2022 оны 4-р сар	2023 оны 4-р сар	
1	ТДЦ	79.2	81.1	19.2	17.1	37.8	39.6	18.1	15.75	-2.35 пунктээр буурсан.
2	ЗЦ	81.5	84.1	24.5	24.5	18.9	22.4	10.1	10.9	+0.85 пунктээр өссөн.
3	ТЦ	77.4	81.7	24.3	24	19.5	22.5	14.1	13.33	Станцын дундаж тоосролт -0.77 пунктээр буурсан.
4	ХЦ	73.1	78.6	21.2	23.2	26.0	29.8			
5	МЦ	87.6	82.5	19.2	20.4	20.6	19.8			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	40 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	Өдөр тутам, эргэлт шалгалтыг тогтмол хийж байна.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	К-3 -ын их засвар, ТГ-7 -ийн дунд засварын ажилд хяналт тавьж ажилласан.

2. Сургалт, зааварчилгаа

1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	255 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	9 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	14 ажилтнаас шалгалт авсан.
4	Бусад сургалтын талаар	100%	Зэрэг ахиж буй 17 ажилтнаас шалгалт авсан.

3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар

1	МХЕГ -ын ХАБУЛ лабораторитой байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	ХАБУЛ лабораторид өгсөн шинжилгээний хариу гарсан. Төв агуулахын усны сорьцонд төмөр 0.3 мг/л байхаас 0.5 мг/л гарсан. Давтан шинжилгээ өгөх болно. "Эрчим зоог" цайны газрын хоол зүйчээр хоолны илчлэгийн харьцуулсан ДҮГНЭЛТ гаргуулсан.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн 6 цехэд хэмжилт хийсэн.
3	Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн. Хэмжилт хийх явцад хяналт тавьж байгаа.

4. Бусад ажлын талаар

- Арьсан бээлий – 2394 ш, химийн бээлий – 149 ш, алгандаа будагтай – 5660 ш, гагнуурын бээлий – 1200 ш, сүлжмэл бээлий – 17193 ш, борооны цув – 117 ш, резинэн бээлий – 3349 ширхийг тус тус хүлээн авсан.
- 2023 оны "ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ АЖИЛ – БИДНИЙ СУУРЬ ЭРХ" уриатай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын АЯН –ы хүрээнд хийх ажлын ТӨЛӨВЛӨГӨӨ гаргаж, гүйцэтгэлийг хангуулсан. Биелэлт – 100%.
- "ОШМИ консталтинг" ХХК –д "Стандартын сургалт" –нд 4 ажилтан хамрагдсан.
- ЗЦ, МЦ –ийн цахилгаан тоноглолтой харьцаж ажилладаг 9 ажилтанд ЦЦ –ийн ХАБ –ын инженерээр ААД –ийн сургалт зохион байгуулсан.
- "ДЦС-3" ТӨХК –ийн ХА –ны үйл ажиллагаа, үйлчлэх цар хүрээтэй ХА –ны дарга, ХАБ –ын инженерүүд танилцсан.
- ISO45001:2018 стандартын ДОТООД АУДИТ –ыг ЗА, ХААХ, НАХ –т хийсэн.

КОМПАНИЙН АЖИЛТНУУДЫН ДУНД УЛАМЖЛАЛ БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Компанийн алба, хэлтэс, цех, нэгж, хэсгүүдэд байгаа техник, технологийн хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, олон улсад нэвтэрч буй шинэ техник, технологийг компанид нэвтрүүлэх, өөрсдийн

хийсэн судалгааны ажлын үр дүнг хамт олонд хүргэж мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах, судалгаа шинжилгээний ажилд сонирхолтой ажилтны идэвх санаачлагыг дэмжих, өрнүүлэх үндсэн зорилготой.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Компанийн хэтийн зорилт, өнөөгийн үйл ажиллагааны хүрээнд инноваци шингэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, шинэ техник технологийг нэвтрүүлэхэд шаардагдах асуудлыг судлан, улмаар үйлдвэрлэлд нэвтрүүлэх, станцын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх нөхцлийг бий болгоход оршино.

ГУРАВ. ИЛТГЭЛИЙН СЭДВИЙН ЧИГЛЭЛ, НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Илтгэлийн сэдвийн чиглэл:

1. Шинэ ажил үйлчилгээ гаргах
2. Шинэ бүтээгдэхүүнийг бий болгох
3. Шинэ техник, технологи нэвтрүүлэх
4. Явцуу шат дамжлагыг илрүүлэх, арилгах
5. Ололт амжилтыг илрүүлэх
6. Асуудал дэвшүүлсэн гэх мэт чиглэлүүдээр илтгэгч илтгэлээ бэлтгэж оролцоно.

Шилдэг, шинэ санал санаачлагын ажлыг компанид нэвтрүүлэх ажлын эхний шалгуур нь тухайн илтгэл байх бөгөөд гаргасан шинэ санаагаа ажил болгох нөхцөл ба дархлааг бүрдүүлж өгнө.

Мөн алба, хэлтэс, цех, нэгжийн жилийн ажлын зорилго, зорилтоо биелүүлэх, ажил хэрэг болгох ажлын биелэлтийн үндсэн шалгуур нь тухайн илтгэл байх бөгөөд асуудалд тооцоо судалгаатай, шинжлэх ухаанчаар хандах үзлийг төлөвлүүлэхэд чиглэгдэнэ.

Илтгэлийн уралдааны нөхцөл:

Илтгэлийн уралдааныг Судалгаа Хөгжлийн Албанаас зохион байгуулах бөгөөд компанийн бүх ажиллагсад өөрсдийн бэлтгэсэн илтгэлээрээ нээлттэй оролцох боломжтой. Илтгэлийн уралдаанд ажилтан дангаараа болон баг, хамт олноороо зохион байгуулалттай оролцож болно.

Илтгэлийн уралдааныг хоёр үе шаттай дүгнэн явуулна. Эхний шатанд ирүүлэх материалыг 2023 оны 06-р сарын 20-ны 09-15 цагийн хооронд СХА-ны 313 тоотод хүлээн авна.

Уралдааныг дүгнэх комисс, ирүүлсэн илтгэлүүдтэй танилцаж, шалгарсан илтгэгч нарт ажлын 14 өдрийн өмнө мэдэгдэнэ.

Уралдааны дараагийн шатанд тэнцсэн илтгэлийг 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Дөл танхимд зохион явуулна.

Илтгэлийн материалын шаардлага:

Уралдаанд оролцох илтгэл нь А4 хэмжээс бүхий цаасан дээр 20

хүртэл нүүр байж болох ба танилцуулах хугацаа 15 минутаас ихгүй байна.

Баримт бичгийн бүрдлүүд нь хэвлэмэл хуудсанд тавигдах нэгдмэл шаардлага, стандартын дагуу хийгдсэн байна. Үүнд:

- Хуудасны дээд, доод талаас 3 см, баруун зүүн талаас 2,5 см-ийн зайтай
- Үсгийн фонд: Arial
- Үсгийн өндөр: 12 point
- Мөр хоорондын зай: 1,5 мөр

Илтгэлийн бүтэц нь: Оршил, Үндсэн хэсэг (а./Судалгааны хэсэг, б./ Дүн шинжилгээ), Дүгнэлт, Хавсралт хэсэг

ЖИЧ: Түлхүүр үг, тайлбар материал, арга зүй, үр дүн, график, зураг, хүснэгт, ашигласан ном зохиол, эх материал гэх мэт зүйлийг оруулсан байх.

Илтгэлийг Office Word программ дээр бэлтгэсэн байна.

Илтгэлд өөрийн нэр, албан тушаал, цех нэгж (алба, хэлтэс, цех, нэгж), холбоо барих утас, e-мэйл хаягийг тодорхой бичиж ирүүлнэ.

Танилцуулах материалаа MSOffice Power point программ дээр бэлтгэсэн байна.

ДӨРӨВ. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ

I шатны шалгаруулалт: Ирүүлсэн бүх илтгэлийг үнэлэхдээ доорх үзүүлэлт тус бүрээр оноо өгч болзол хангасан илтгэлүүдийг 2-р шатанд шалгаруулан хэлэлцүүлэхээр үлдээнэ.

- Илтгэлийг бэлтгэж ирүүлсэн байдал 1 – 3 оноо
- Баримт бичиг боловсруулах шаардлага хангасан байдал 1 – 3 оноо
- Судалгаа, шинжилгээний ажлын гүйцэтгэл 1 – 5 оноо
- Эдийн засгийн үр ашиг, хэмнэлтийн тооцоо гаргасан байдал 1 – 5 оноо
- Дүгнэлт 1 – 3 оноо

14 ба түүнээс дээш оноо авсан илтгэлийг болзол хангасан гэж тооцон 2-р шатанд шалгаруулна.

II шатны шалгаруулалт: Нийтэд танилцуулагдах илтгэлүүдийг доорх үзүүлэлтүүдээр үнэлгээ өгч шалгаруулна.

- Сэдвийн агуулга ач холбогдол 1 – 5 оноо
- Байгууллагад хэрэгжүүлэх боломжтой эсэх 1 – 5 оноо
- Судалгааны ажлын гүйцэтгэл 1 – 5 оноо
- Илтгэх үр чадвар 1 – 3 оноо
- Эдийн засгийн үр өгөөж, тооцоо 1 – 5 оноо
- Байгаль орчинд ээлтэй эсэх 1 – 3 оноо


Шүүгчдийн үнэлгээгээр хамгийн их оноо авсан дарааллаар илтгэлийг шалгаруулна.

ТАВ. УРАЛДААНЫГ ШАЛГАРУУЛАХ КОМИСС

Комиссын даргаар “ДЦС-4” ТӨХК-ийн Ерөнхий инженер, гишүүдээр ХА, YA, СХА-ны дарга нар мөн “Эрчим хүч & инженеринг” сэтгүүлийн редакциас 1-2 хүн, комиссын нарийн бичгийн даргаар СХА-ны ЗБТСХ-ийн патентын мэргэжилтэн нар ажиллана.

ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- | | | |
|---|-----------|------------|
| 1. Тэргүүн байр (нэг) | Өргөмжлөл | 1.000.000₮ |
| 2. Дэд байр (нэг) | Өргөмжлөл | 500.000₮ |
| 3. Тусгай байр (нэг) | Өргөмжлөл | 250.000₮ |
| 4. 2-р шатанд шалгарсан илтгэл тус бүрийг | | 100.000₮ |





“CES 2023” ҮЗЭСГЭЛЭН

Технологийн ертөнцийн хамгийн том үйл явдлуудын нэг болдог “CES (Consumer Electronic Show) 2023” үзэсгэлэн АНУ-ын Лас-Вегас хотноо болж 100 мянга орчим хүн үзэж сонирхжээ. Иргэдийн өргөн хэрэглээний барааны технологийн хамгийн сүүлийн үеийн чиг хандлагыг тодорхойлдог уг үзэсгэлэнд 173 орны 3200 гаруй бүтээгдэхүүн танилцуулагдаж байна. Энэхүү үзэсгэлэнг “дэлхийн хамгийн шинэлэг технологи, инновацыг бүтээгчдийн цуглаан” гэж нэрлэдэг бөгөөд энэ жил дэлхийн хамгийн том 500 компаниас 323 нь оролцож байгаа ажээ. Үзэсгэлэнгийн үеэр 200 гаруй бага хурал, дугуй ширээний уулзалт ярилцлага болсон бөгөөд үүнд 750 орчим илтгэгч оролцсон байна. Тус үзэсгэлэнд технологийн салбарын 115,000 мянган мэргэжилтэн оролцож шинэ содон технологиудыг хэрэглэгчдэд танилцуулжээ. Тухайлбал, өнгө нь солигддог суудлын машин, хувийн зориулалтын ухаалаг нисдэг тэрэг, илгээмж зөөдөг дронуд, робот гэрийн гэжээвэр амьтан, гэр дотор ашиглах дрон камер, дуу чимээ багасгагч маск, шээсээ гэрийн нөхцөлд шинжлэх боломжтой “u-scan” зэргийг онцолж болох ажээ.

Уламжлал ёсоор дэлхийн томоохон үйлдвэрлэгчид Лас Вегаст шинэчлэгдсэн зурагтуудаа танилцуулсан байна. Гэхдээ энэ удаад “Sony” оролцолгүй үлдсэн ч “LG”, “Samsung” болон мөн жижиг үйлдвэрлэгчид юу хийж бүтээснээ дэлгэн харуулжээ. “LG”-гийн дэлхийн хамгийн том, 97 инчийн “OLED” зурагт зочдыг гайхшруулж байна. Гэхдээ дэлгэцийн хэмжээ бус, харин уг зурагт ямар ч утасгүй болсон нь тэднийг гайхшруулжээ.

Өөрөөр хэлбэл, “4K” нягтаршилтай дүрсийг утасгүйгээр “агаараар” дамжуулдаг болсон аж. Ингэхийн тулд тэд зурагтаа хэд хэдэн “HDMI” холбогчтой шоо хэлбэрийн тусдаа орших дамжуулагчаар тоногдсон байна. Ямар ч дохионы эх үүсвэр энэ шоонд холбогдох бөгөөд уг шоо зургийг утас шаардахгүйгээр зурагт руу илгээдэг гэнэ. Шоо хэлбэрт хайрцаг нь TV хүлээн авагчаас 10 метрийн зайд байрлаж 120 Гц давтамжаар 4K нягтралтай дүрс дамжуулдаг байна. TV нь өөрөө цахилгаанд залгагдах ганц утастай аж. Уг төхөөрөмж 25,000 гаруй ам.долларын үнэтэй юм.



Энгийн зурагтын хувьд 2023 онд гарсан шинэлэг зүйл нь “Brightness Booster Max технологи” гэх зургаа дахь үеийн процессоруудын ачаар хамаагүй илүү тод гардаг болж 70 хувиар илүү гэрэлтэй болжээ. Тухайлбал, “Samsung” програм хангамжийн шинэчлэлд ихээхэн анхаарал хандуулж, өөрийн

“Tizen OS” зурагтанд хараа муутай хүмүүст зориулсан сайжруулсан зургийн горим, теле анагаах ухааны програм, “Chat Together” мессенжер байрлуулжээ. Энэ нь та буйдан дээрээсээ босохгүйгээр фотоплетизмограф технологи ашиглан зүрхний цохилт, цусны даралт, хүчилтөрөгчийн ханалт, стрессийн индекс, амьсгалын давтамж зэрэг мэдээллээ авах боломжтой болсон гэсэн үг юм. Бусад сонирхолтой шинэ бүтээгдэхүүнүүд нь “Hisense”, “Dis-place” TV загварууд юм. Эхнийх нь шинэ “ULED X” технологи бүхий 85 инчийн телевизор бөгөөд энэ нь “OLED” шиг тусдаа технологи биш, харин 20 мянган “мини LED” арын гэрэлтүүлэг юм. Энэ бүхэн нь тухайн нөхцөлд тохируулан дүрсний тод байдлыг нэмэгдүүлж, өнгийг сайжруулах ажлыг хиймэл оюун ухаан хийдэг гэсэн үг гэнэ. Мөн “Startup Displace” TV нь “LG”-ийн зурагттай адил утасгүй, гэхдээ зөөврийн, сольж болдог батерейгаар ажилладаг аж. Алсын удирдлагыг гар дохио эсвэл ухаалаг гар утсан дээрх аппликейшн ашиглан хийдэг болжээ.


Компьютерын H, P, U процессорууд мөн шинэчлэгдэн хэмжээ нь багасаж эрчим хүчний зарцуулалт нь мэдэгдэхүйц багассан байна. “N-series” чип нь зөөврийн компьютерт зориулагдсан бөгөөд эдгээр чипүүд нь “Pentium/Celeron” шугамыг орлох зориулалттай бөгөөд зөөврийн компьютерт зориулагдсан аж. “AMD” ч тэднээс хоцроогүй бөгөөд гар утас болон ширээний компьютерийн чипийн шинэчлэлээр шүтэн бишрэгчдээ баярлуулсан байна. Учир нь “AMD”-ийн шинэ бүтээгдэхүүний гүйцэтгэл нь өмнөх “Ryzen 6900HX”-тэй харьцуулахад 78 хувиар өсөж, 34 хувь илүү хурдан болсон гэнэ. Үүний зэрэгцээ “7940HS”-тэй зөөврийн компьютер нэг цэнэглэлтээр 30 цаг хүртэл ажиллах боломжтой болжээ.



“A S U S” компани “CES 2023” үзэсгэлэнд “Vivobook Pro 16X 3D” болон “StudioBook 16” зөөврийн компьютеруудыг авчирчээ. Аль аль нь “OLED” дэлгэцээр тоноглогдсон

бөгөөд тусгай нүдний шил зүүх шаардлагагүйгээр дэлгэцийг “3D” дүрсээр үзэх боломжтой болсон аж. Бас хэрэглэгчийн толгойны хөдөлгөөнийг хянаж, стереоскоп дүрсийг тохируулж өгдөг мэдрэгчүүдтэй болжээ.

Урьдын адил технологийн шинэчлэлүүд хүний эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулжээ. Жишээлбэл, “Valencell” компани ханцуйвч



шаардлагагүй цусны даралт хэмжигчийг үзүүлэв. Уг төхөөрөмж нь пульсоксиметр шиг хэрэглэгчийн хуруунд бэхлэгддэг байна. Цусны даралтыг минут хүрэхгүй хугацаанд хэмжих тул урьдчилсан тохируулга хийх шаардлагагүй аж. Борлуулалт нь энэ оны сүүлээр 100 орчим долларын үнээр эхлэх төлөвтэй байна.

Үргэлжлэл дараагийн хуудсанд




Харин “Withings” компани хэрэглэгчийг бие засах бүрт U-Scan” төхөөрөмжөө танилцуулав. Тэгвэл “Acer” компани “eKinect BD 3” гэх компьютерийн ширээ авчирчээ. Энэ ширээний онцлог нь та компьютер дээр ажиллахдаа дасгалын дугуйн дээр зэрэг дасгал хийхээс гадна цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж гаджетуудаа

цэнэглэх боломжтой юм байна.



Канадын “Glückkind” стартапын хүүхдийн ухаалаг тэрэг “Элла” үзэгчдийн сонирхлыг ихээхэн татав. “Элла” тэрэг нь бие даан хөдөлж, ээж, аавын гарыг чөлөөлөөд зогсохгүй явган хүний зам дээрх саад бэрхшээлийг таньж, зайлан гарч чаддаг аж. Бариул дээрх дуу чимээ, анивчдаг “LED” гэрэл бүхий хүүхдийн уг тэрэг нь дугуйтай яваа эсвэл хажуугаар өнгөрч буй хүмүүстэй мөргөлдөх аюулаас эцэг эхчүүдийг анхааруулах чадвартай юм байна. Мөн “Samsung Bespoke Home” цахилгаан зуух нь мэдрэгч, камер, хиймэл оюун ухаанаар тоноглогдсон бөгөөд 80 гаруй хоолыг таньж, тэдгээрийг бэлтгэх тохиргоог оновчтой хийдэг аж. Үүнээс гадна зууханд хоол түлэгдэж эхэлбэл мэдэгдэх гэнэ. Хэрэв та ямар хоол хийхээ шийдэж чадахгүй байгаа бол уг төхөөрөмж танд ямар хоол хийвэл



танд тохирохыг зөвлөх төдийгүй хийхэд чинь туслах ажээ.

Эцэст нь сануулахад, бидний цоо шинэ гээд байгаа, иргэдийн өргөн хэрэглээний барааны “CES” үзэсгэлэнгийн технологиуд нь яг үнэндээ цэрэг, зэвсэглэлд ашиглагдахаа больж, олон нийтэд гаргаж байгаа хуучин технологиуд юм. Өнөөдөр мундаг гэгдээд байгаа барууны зэвсгүүд нь өнгөрсөн зууны 70, 80-иад оны технологиуд. Харин барууны улсууд эдгээр хуучин зэвсгүүдээ халах, нисгэгчгүй онгоц, хүнгүй танк гэх мэт шинэ технологийн зэвсгүүд үйлдвэрлэж эхлэн, цэргийнхний хувьд маш сайхан завшаан болох Орос, Украины дайнд туршин баараггүй болгож байгаа нь ойлгомжтой. Иймээс ирэх 2024-2025 оны “CES 2023” үзэсгэлэнд тавигдах иргэний өргөн хэрэглээний бараануудын хувьд эдгээр хуучин зэвсгийн нь мэдрэгч, камер, хиймэл оюун ухаанаар тоноглогдсон бөгөөд 80 гаруй хоолыг таньж, тэдгээрийг бэлтгэх тохиргоог оновчтой хийдэг аж. Үүнээс гадна зууханд хоол түлэгдэж эхэлбэл мэдэгдэх гэнэ. Хэрэв та ямар хоол хийхээ шийдэж чадахгүй байгаа бол уг төхөөрөмж танд ямар хоол хийвэл танд тохирохыг зөвлөх төдийгүй хийхэд чинь туслах ажээ.

СХА-ны Мэдээлэл технологийн хэсэг

СПОРТЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ



Олс таталтын 2023 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээн 2023 оны 4-р сарын 30-нд “Аварга” дээд сургуулийн дэргэдэх спорт, сургалтын төвд амжилттай болж өндөрлөө. 2004 онд анх зохион байгуулагдаж, жил бүр уламжлал болон зохиогдож байгаа энхүү тэмцээн эрэгтэй 620 кг, эмэгтэй 520 кг, холимог 580 кг гэсэн жин, төрлөөр зохион байгуулагдсан.

Тэмцээнд “ДЦС-4” ТӨХК, “Аварга” дээд сургууль, Багануур дүүргийн “Уурхайчин” баг, Зэвсэгт хүчний 032-р анги, ХААИС, Зэвсэгт хүчний 330-р анги, Тэс клуб, Багануур дүүргийн БТСХорооны баг зэрэг 10 байгууллагын 150 орчим тамирчин оролцсон юм.

Уг тэмцээний холимог төрөлд манай баг Тэргүүн байр эзэллээ.



Волейболын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 4-р сарын 18-25-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт хоёр дахь удаагаа зохион байгуулагдаж, дүнгээ гаргалаа. Энэ удаагийн тэмцээнд 19 багийн 228 тамирчин ур чадвар, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдсөнөөс эрэгтэй багийн төрөлд аваргын төлөө “ДЦС-4” ТӨХК-ийн “Эрчим” баг, УБТЗ-ын “Замчин” багтай эн тэнцүү өрсөлдөж 2-хон онооны зөрүүтэй хожигдож, 2-р байр эзэлсэн байна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн нэрэмжит “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-ын төлөөх спортын 5 төрөлт тэмцээнийг 2023 оны 5-р сарын 2-ноос 7-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж дууссан байна.

Тэмцээнд хот, нийтийн аж ахуй, инженер хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 22 байгууллагын 800 гаруй тамирчид оролцлоо. Уг тэмцээнд манай тамирчид доорхи амжилтуудыг гаргалаа.

- Эрэгтэй теннис **Тэргүүн байр** Л. Мягмарсүрэн /СХА/;
- Эрэгтэй шатар **Тэргүүн байр** Э.Энхнар /НАХ/;
- Дартсын төрөлд багийн төрлөөр Б.Давааням/ДХХАЦ/, С.Намхайсүрэн /ДХХАЦ/, М.Батцэцэг /МЦ/, З.Номин-Эрдэнэ /МЦ/ нар **3-р байр**;
- Эмэгтэй волейбол **Тэргүүн байр**;
- Эрэгтэй сагсан бөмбөг **3-р байрт** тус тус шалгарсан байна.


Нийлбэр дүнгээр манай компанийн баг тамирчид **2-р байр** эзэллээ. Тэмцээнд оролцсон нийт баг, тамирчиддаа спортын өндөр амжилт хүсье.





БҮСЭЛХИЙ НУРУУНЫ ӨВДӨЛТ

Нурууны өвдөлт нь дэлхий дахинаа түгээмэл тохиолддог өвчлөлийн нэг бөгөөд насанд хүрэгчдийн 60–70 % нь амьдралынхаа туршид ямар нэгэн байдлаар нурууны өвдөлт мэдэрсэн байдаг ба 35–55 насны хүмүүсийн дунд хамгийн их тохиолддог өвчлөлийн нэг юм.



Бүтцийн хувьд хүний багана нуруу нь хүзүүний–7, цээжний–12, бүсэлхийн–5, ууцны –5, ахар сүүлний–4 буюу нийт 33 нугаламаас бүрдэнэ. Багана нуруу нь хүзүү бүсэлхий гэсэн хэсэгтээ хотгор, харин сээр ууц гэсэн хэсэгтээ гүдгэр үүсгэж байрладаг онцлогтой. Нуруу нь биеийн гол тулгуур тэнхлэг болохын зэрэгцээ их биеийн хөдөлгөөнийг нөхцөлдүүлж, уян хатан байдлыг хангаж нугасыг хамгаалж байдаг чухал эрхтэн юм. Нугаснаас салбарлах мэдрэлийн салаа, тэдгээрийн зангилаануудыг мөн багана нурууг дагаж байрладаг артери венийн судсуудыг хамгаалдаг. Нугалам хооронд мөгөөрсөн жийргэвч буюу диск байрлах бөгөөд энэ нь 2

нугаламыг тусгаарлаж хөдөлгөөн хийх боломжийг бүрдүүлэх ба мөн гаднаас ирэх даралт доргилтыг шингээх үүрэгтэй байдаг. Нугалам хоорондын диск нь 3 хэсгээс бүрдэх ба гадна талдаа фиброзон цагирган бүрхүүл үүний дотор талд гель маягийн шингэн, энэ 2–н дээр болон доор хэсгүүдэд нимгэн мөгөөрсөн таваг байрладаг. Дотор талын цөмийн ихэнх хэсгийг ус, үлдсэн хэсгийг кератин сульфат болон хондритин сульфат агуулдаг протеогликан гэх уураг бүрдүүлдэг.

Шалтгаан: Нурууны өвдөлтийн шалтгаан нь харьцангуй өргөн хүрээг хамардаг. Шалтгаануудаас нь хамаараад өвөрмөц бус, механик, механик бус болон бусад өвчнөөс үүдэлтэй гэж ангилдаг. Өвөрмөц бус нурууны өвдөлт нь нийт тохиолдлын ойролцоогоор 70%–ийг эзэлдэг бөгөөд ихэнх тохиолдолд хүнд зүйл өргөх, огцом хөдөлгөөн хийх зэргээс болж булчингийн чангарал, булчин болон холбоосуудын суналтаас үүдэлтэй үүсдэг. Механик нурууны өвдөлтөнд нурууны дискийн дегенератив өөрчлөлтүүд буюу элэгдэл, дискийн ивэрхий, нуруу нугаламын гулсалт, настай хүмүүст ясны сийрэгжилттэй холбоотойгоор нугаламын шахагдсан хугарал, гэмтлээс улбаалсан нугаламын хугарал, нурууны мурийлт, нугасны сувгийн нарийсалт багтана. Механик бус шалтгаанууд нь харьцангуй цөөн тохиолддог. Үүнд: нуруу нугасны хавдар бусад эрхтэнүүдийн үсэрхийлсэн хавдар, ясны сүрьеэ, ревматологийн өвчнүүд болох спондилоартропати буюу нурууны үений архаг үрэвсэлт өвчнүүд мөн бусад халдварууд багтана. Монголчуудын хувьд ялангуяа 40–өөс дээш насныхны нурууны өвдөлтийн гол шалтгаан нь нугалам хоорондын дискийн дегенератив өөрчлөлт /элэгдэл/, ард түмний дунд остеохондроз нэрээр буюу нурууны шохойжилт өвчин юм. Нурууны нугалам хоорондын дискийн дегенератив өөрчлөлтөнд нөлөөлдөг хэд хэдэн хүчин зүйлс байдаг.

1. Насжилт – нас ахих тусам дискийн дотор цөмийг бүрдүүлэгч протеогликан уургийн синтез буураад задрал нь нэмэгддэг. Ялангуяа хондритин сульфатын синтез буурдаг. Улмаар хондритин сульфат болон кератин сульфатын харьцаа нь багасаж өгдөг. Хондритин сульфат багассанаар дискийн усыг татах чанар нь алдагдаад диск хуурайшиж хатууран нимгэрч эхэлдэг. Улмаар нугалам хоорондын зай багасдаг.
2. Хөдөлгөөн – Хөдөлгөөнгүй удаан суух үед дискэнд хэрэгтэй шим тэжээл болон шингэн очиж чаддаггүй. Нугалам хоорондын диск нь хүний биеийн хамгийн том судасжилтгүй эд бөгөөд шим тэжээл болон усыг ойр орчмын нугалам болон холбоосон эдийн цусны сүлжээнээс нэвчилтийн аргаар мөгөөрсөн тавгаараа дамжуулан авдаг. Энэхүү нэвчилтэнд хөдөлгөөн голлох үүрэг гүйцэтгэдэг байна.
3. Генетик фактор нилээн том үүрэг гүйцэтгэдэг.
4. Хорт бодисууд буюу ялангуяа тамхи. Тамхинд агуулагдах никотин нь дискийн үндсэн эсийн нөхөн төлжилтийг саатуулдаг байна. Мөн үүнээс гадна хэт их даралт болон эргэлтээс шалтгаалсан механик гэмтлүүд нь дискийн мөгөөрсөн тавагны хугарал үүсгэдэг ба гаднах цагирган бүрхүүл нь гадагш түлхэгдэн нугалмуудын их бие рүү давж цүлхийнэ. Дискийн цүлхийсэн хэсэг нь нугаснаас салбарласан мэдрэлийн салаануудыг хавчин дарснаас тухайн мэдрэлийн судлуудын мэдрэлжүүлдэг биеийн хэсэгт өвдөлт бадайрал мэдрэгдэнэ.

Илрэх шинж тэмдэг:

- Нуруу гэнэт татах
- Хөдөлгөөн болон ачааллын үед бүсэлхий нуруугаар хүчтэй хатгуулж өвдөх
- Нуруунаас хөл рүү дамжиж өвдөх /гуя, тахим, шилбэ рүү өвдөлт дамжих/
- Нуруугаа хөдөлгөж болохгүй байх
- Нуруу тэгш байдлаа алдаж аль нэг тал руугаа хазайх /нурууны булчин чангарсантай холбоотой/

Оношлогоо:

- Рентген зураг
- Компьютер томографи шинжилгээ, MRI
- Цусны шинжилгээ (нурууны өвдөлт үүсгэх халдвар авсан эсэхийг шинжлэх)
- Мэдрэл болон мэс заслын эмчийн үзлэг

Эмчилгээ:

- Эмийн эмчилгээ – өвчин намдаах, үрэвслийн эсрэг бэлдмэлүүд, булчин сулруулах эм, мөн дискний цөмийг бүрдүүлэгч протеогликан болох хондритин сульфатыг нэмэлтээр хэрэглэх хэрэгтэй.
- Физик эмчилгээ
- Мэс засал эмчилгээ

Урьдчилан сэргийлэлт:

- Хөдөлгөөн – дискийг тэжээлээр баялаг байлгах шаардлагатай. Нурууны булчин, үе холбоосыг бэхжүүлэх дасгал хийх. Усанд сэлэх, алхах, гүйх зэрэг дасгалыг тогтмол хийж байх
- Хүнд зүйл аль болох өргөхгүй байх. Хэрэв өргөхөөр болвол доош сууж гуяны булчиндаа ачаалал өгч болгоомжтой өргөх,
- Илүүдэл жингээ хасах
- Зөв сууж сурах /Сандал дээр суухдаа суудалдаа хойшоогоо бүрэн налж цэх суух, нурууны ард жижиг зөөлөвч хийн нурууг дэмжих/
- Нэг байрлалд удаан суухгүйгээр зогсох, суух зэргээр хөдөлгөөн хийж нуруугаа амраах
- Удаан хугацаанд жолоо барихдаа дунд нь зогсож амрах
- Хүнд ачаатай цүнх үүрэхдээ хоёр мөрөндөө ээлжилж үүрэх
- Хорт зуршлаас сэргийлэх /тамхинаас татгалзах/



Ашигласан ном материал: Нурууны мэдрүүлийн өвдөлтийн хам шинжийн оношлогоо, эмчилгээний стандарт

Эмнэлэгийн хэсэг